



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот


Журамд өөрчлөлт оруулах  
тухай

Монгол Улсын “Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дах заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” 79 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын яамны зарим чиг үүргийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд шилжүүлсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Фармакопейн хорооны ажиллах журам”-ын хоёр дугаар хавсралтын 2.3 дах заалтын ...Эрүүл мэндийн яам гэснийг Эрүүл мэндийн хөгжлийн төв... гэж, гурав дугаар хавсралтын 2.1, 2.4, 2.6 дах заалтын ...Эрүүл мэндийн сайдын тушаалаар... гэснийг ...Эрүүл мэнд, спортын сайдын тушаалаар... гэж, 3.4.4 дах заалтын Туршилтын 3 цувралыг ... гэснийг ... туршилтын цувралыг гэж тус тус өөрчилсүгэй.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат- Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-д, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/ нарт тус тус үүрэг болгосугай.



САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080296